



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/223

Булган

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах  
эрх олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгагдсан Ус хангамж, ариутгах татуурга, төвлөрсөн шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулах /Дашинчилэн сум/ зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан Улаанбаатар хотын “Мон кузбасс” ХХК-тай 42 000 000 /дөчин хоёр сая/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Ү.Бямбасүрэн/-д олгосугай.

2. Дээрх ажлын гүйцэтгэгчтэй холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Д.Буманбаяр/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Ү.Бямбасүрэн/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Зураг төсвийг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Мон кузбасс” ХХК-ийн захирал /Ж.Ганболд/-д даалгасугай.

4. Энэхүү ажлыг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу 2019 оны Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /Б.Очирсүрэн/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ